



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/11/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Говь-Алтай аймаг Алтай хот 2021 он	Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a> Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Б.Цэцэгмаа Утас: 99488754 Цахим хаяг: <a href="mailto:tsetsegmaab@audit.gov.mn">tsetsegmaab@audit.gov.mn</a>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	12
3. Аудитын тайлан .....	13
3.1 Ерөнхий зүйл .....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	13
3.4 Материаллаг байдал .....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	15
3.8 Аудитын гол асуудал .....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
4. Аудитын илрүүлэлт .....	17
4.1 Залруулсан алдаа .....	17
4.2 Төлбөрийн акт .....	17
4.3 Албан шаардлага .....	17
4.4 Зөвлөмж .....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	19

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.25 № 111

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Татварын тодорхойлолтоор өглөг, авлагатай, нийгмийн даатгалын тайланг илүү тайлагнасан, иргэдийн хандивыг данс бүртгэлд тусгаагүй, үлдэх өртөгтэй тээврийн хэрэгслийг данс бүртгэлээс хассан 44.4 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалттай нийцэхгүй, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


07022228

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

		/ төгрөгөөр /	
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	274,161,862.00	292,054,812.00
33	АВЛАГА	12,999,900.00	2,000,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	10,999,900.00	0.00
33500	Бусад авлага	2,000,000.00	2,000,000.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	2,000,000.00	2,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	261,161,962.00	290,054,812.00
35400	Хангамжийн материал	60,517,962.00	89,410,812.00
35410	Бичиг хэргийн материал	199,170.00	2,432,220.00
35420	Аж ахуйн материал	58,128,792.00	85,038,592.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,190,000.00	1,190,000.00
35440	Түлш, шатах тослох материал	250,000.00	0.00
35470	Бусад хангамжийн материал	750,000.00	750,000.00
35600	Мал амьтад	200,644,000.00	200,644,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,075,055,600.65	926,986,674.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,075,055,600.65	926,986,674.00
39200	Биет хөрөнгө	1,046,940,309.06	898,934,674.00
39201	Барилга, байгууламж, орон сууц	794,029,707.84	827,459,707.84
39202	Хуримтлагдсан элэгдэл	-249,524,681.87	-289,938,651.55
39203	Авто-тээврийн хэрэгсэл	75,803,160.00	79,953,160.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-25,715,078.20	-15,182,535.06
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	94,404,054.00	44,163,490.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-63,029,898.20	-22,051,361.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	36,377,038.00	23,718,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-18,139,666.85	-8,714,847.95
39209	Зам, гүүрийн байгууламж	265,440,049.00	285,439,949.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-34,947,762.36	-190,639,525.18
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	130,962,500.00	130,962,500.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	218,413,500.00	199,101,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-177,132,612.30	-165,336,212.10
39300	Биет бус хөрөнгө	28,115,291.59	28,052,000.00
39301	Програм хангамж	1,270,000.00	490,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,206,708.41	-490,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	28,052,000.00	28,052,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,349,217,462.65	1,219,041,486.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,349,217,462.65	1,219,041,486.00
51	Засгийн газрын хувь оролцоо	1,349,217,462.65	1,219,041,486.00
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	389,151,152.00	389,151,152.00
51200	Хуримтлагдсан үр дүн	591,277,955.51	461,101,978.86
51210	Өмнөх үеийн үр дүн	365,752,094.28	591,277,955.51
51220	Тайлант үеийн үр дүн	225,525,861.23	-130,175,976.65
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	368,788,355.14	368,788,355.14
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,349,217,462.65	1,219,041,486.00

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	733,501,832.00	488,733,408.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	343,359,316.00	130,036,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	343,359,316.00	130,036,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	343,359,316.00	130,036,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	800,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.00	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	342,759,316.00	129,236,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	390,142,516.00	358,696,608.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	74,402,616.00	16,892,208.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,992,900.00	3,800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	51,409,716.00	12,232,208.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	860,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	315,739,900.00	341,804,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	315,739,900.00	341,804,400.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	507,975,970.77	603,294,637.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	507,975,970.77	603,294,637.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	493,430,170.14	583,556,725.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	205,233,313.11	205,547,617.00
210101	Үндсэн цалин	139,114,679.11	115,283,247.00
210102	Нэмэгдэл	29,158,172.00	55,534,540.00
210104	Урамшуулал	31,000,000.00	29,574,483.00
210105	Гэрээт ажлын хөлс	5,960,462.00	5,155,347.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,789,646.26	27,226,887.43
210201	Тэтгэврийн даатгал	17,572,646.26	18,863,000.43
210202	Тэтгэмжийн даатгал	1,653,900.00	2,092,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,065,400.00	1,668,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	408,900.00	408,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,088,800.00	4,194,787.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,880,898.00	35,615,047.00
210301	Гэрэл, цахилгаан	1,457,506.00	1,571,471.00
210302	Түлш, халаалт	27,023,392.00	33,043,576.00
210303	Цэвэр, бохир ус	400,000.00	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	106,899,260.00	48,917,000.00
210401	Бичиг хэрэг	2,752,360.00	2,597,080.00
210402	Тээвэр, шатахуун	48,701,950.00	35,043,420.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,630,000.00	1,796,600.00
210404	Ном, хэвлэл	193,200.00	243,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	2,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	53,501,750.00	7,236,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	1,787,500.00
210604	Урсгал засвар	0.00	1,787,500.00
2107	Томилолт, зочны зардал	2,340,000.00	1,497,800.00
210702	Дотоод албан томилолт	2,340,000.00	1,497,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,072,530.00	16,907,995.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,363,776.00	15,376,788.00
210803	Даатгалын үйлчилгээ	358,900.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	70,330.00	116,038.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	50,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	320,000.00	240,000.00

Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210807	Газрын төлбөр	915,524.00	645,169.00
210813	Бусад зардал /ТӨҮГ/	0.00	180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	99,214,522.77	246,056,879.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,612,998.00	8,992,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	84,601,524.77	237,064,679.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,545,800.63	19,737,911.57
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,815,500.00	9,448,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,815,500.00	9,448,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	9,730,300.63	10,289,411.57
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,730,300.63	9,407,411.57
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	882,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	225,525,861.23	-114,561,229.50
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	15,614,747.15
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	15,614,747.15
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	225,525,861.23	-130,175,976.65

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	389,151,152.00	368,788,355.14	365,752,094.28	1,123,691,601.42
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	389,151,152.00	368,788,355.14	365,752,094.28	1,123,691,601.42
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	225,525,861.23	225,525,861.23
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	389,151,152.00	368,788,355.14	591,277,955.51	1,349,217,462.65
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	389,151,152.00	368,788,355.14	591,277,955.51	1,349,217,462.65
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	389,151,152.00	368,788,355.14	591,277,955.51	1,349,217,462.65
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-130,175,976.65	-130,175,976.65
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	389,151,152.00	368,788,355.14	461,101,978.86	1,219,041,486.00

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/ төгрөгөөр /	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	390,742,516.00	370,496,508.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	600,000.00	800,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	600,000.00	800,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	600,000.00	800,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	800,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	390,142,516.00	369,696,508.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	74,402,616.00	27,892,108.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,992,900.00	3,800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	51,409,716.00	23,232,108.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	860,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	315,739,900.00	341,804,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	315,739,900.00	341,804,400.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	384,742,516.00	370,496,508.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	384,742,516.00	370,496,508.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	359,196,815.37	350,758,596.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	205,233,313.11	205,547,617.00
210101	Үндсэн цалин	139,114,679.11	115,283,247.00
210102	Нэмэгдэл	29,158,172.00	55,534,540.00
210104	Урамшуулал	31,000,000.00	29,574,483.00
210105	Гэрээт ажлын хөлс	5,960,462.00	5,155,347.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,789,646.26	27,226,887.43
210201	Тэтгэврийн даатгал	17,572,646.26	18,863,000.43
210202	Тэтгэмжийн даатгал	1,653,900.00	2,092,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,065,400.00	1,668,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	408,900.00	408,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,088,800.00	4,194,787.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,880,898.00	35,365,047.00
210301	Гэрэл, цахилгаан	1,457,506.00	1,571,471.00
210302	Түлш, халаалт	27,023,392.00	32,793,576.00
210303	Цэвэр, бохир ус	400,000.00	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	57,267,430.00	53,613,550.00
210401	Бичиг хэрэг	2,951,530.00	4,875,130.00
210402	Тээвэр, шатахуун	48,701,950.00	35,043,420.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,630,000.00	1,796,600.00
210404	Ном, хэвлэл	193,200.00	243,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	2,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,670,750.00	9,654,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	1,787,500.00
210604	Урсгал засвар	0.00	1,787,500.00
2107	Томилолт, зочны зардал	2,340,000.00	1,497,800.00
210702	Дотоод албан томилолт	2,340,000.00	1,497,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,072,530.00	16,727,995.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,363,776.00	15,376,788.00
210803	Даатгалын үйлчилгээ	358,900.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	70,330.00	116,038.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	50,000.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	320,000.00	240,000.00
210807	Газрын төлбөр	915,524.00	645,169.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,612,998.00	8,992,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,612,998.00	8,992,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,545,700.63	19,737,911.57
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,815,500.00	9,448,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,815,500.00	9,448,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	20,730,200.63	10,289,411.57
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,730,300.63	9,407,411.57
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	10,999,900.00	882,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	6,000,000.00	0.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	6,000,000.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,000,000.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	6,000,000.00	0.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,000,000.00	0.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-6,000,000.00	0.00
100	Тохируулгын орлого, зарлагын зөрүү	0.00	0.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

			/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	342,524,400.00	333,196,988.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	342,524,400.00	333,196,988.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	333,044,400.00	323,748,488.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	211,205,000.00	205,547,617.00
210101	Үндсэн цалин	125,900,000.00	115,283,247.00
210102	Нэмэгдэл	57,600,000.00	55,534,540.00
210104	Урамшуулал	25,080,000.00	29,574,483.00
210105	Гэрээт ажлын хөлс	2,625,000.00	5,155,347.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,135,600.00	27,226,887.43
210201	Тэтгэврийн даатгал	19,663,400.00	18,863,000.43
210202	Тэтгэмжийн даатгал	2,118,100.00	2,092,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,694,400.00	1,668,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	423,600.00	408,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,236,100.00	4,194,787.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,657,900.00	35,365,047.00
210301	Гэрэл, цахилгаан	1,800,000.00	1,571,471.00
210302	Түлш, халаалт	32,857,900.00	32,793,576.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	42,477,400.00	41,941,930.00
210401	Бичиг хэрэг	4,668,600.00	4,661,130.00
210402	Тээвэр, шатахуун	25,000,000.00	24,977,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,265,000.00	1,796,600.00
210404	Ном, хэвлэл	272,000.00	243,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	2,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,271,800.00	8,262,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,790,000.00	1,787,500.00
210604	Урсгал засвар	1,790,000.00	1,787,500.00
2107	Томилолт, зочны зардал	1,500,000.00	1,497,800.00
210702	Дотоод албан томилолт	1,500,000.00	1,497,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,278,500.00	1,389,507.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,513,500.00	38,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	130,000.00	116,038.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	50,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	240,000.00
210807	Газрын төлбөр	1,045,000.00	645,169.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,000,000.00	8,992,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,000,000.00	8,992,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,480,000.00	9,448,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,480,000.00	9,448,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,480,000.00	9,448,500.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	342,524,400.00	333,196,988.43
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	341,804,400.00	332,396,988.43
320001	Орон нутгийн төсвөөс	341,804,400.00	332,396,988.43
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	720,000.00	800,000.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	720,000.00	800,000.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	/ төгрөгөөр / ТАЙЛАНТ ОН
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	27,892,108.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	27,892,108.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	27,010,108.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	11,671,620.00
210401	Бичиг хэрэг	214,000.00
210402	Тээвэр, шатахуун	10,065,620.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,392,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	15,338,488.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,338,488.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	882,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	882,000.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	882,000.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	27,892,108.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	27,892,108.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,232,108.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	860,000.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Цэцэгмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Засаг даргын тамгын газар нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03/28 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Засаг даргын тамгын газар нь сумын Засаг даргын хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрх, үйл ажиллагааныхаа хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нь цаг үеэ олсон, оновчтой зөвлөгөө, мэдээллээр ханган бүх талын дэмжлэг үзүүлж, төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй чанарын өндөр түвшинд хүргэх чиг үүрэгтэй сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй харин Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Засаг даргын тамгын газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал болох 518.9 сая төгрөгөөс 2 хувиар буюу 10.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 8.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 63 хувиар буюу 130.2 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант онд 341.8 сая төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн төсвөөс, 27.9 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт, туслах үйл ажиллагааны орлогоос 0.8 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж оны эцэст 10.3 сая төгрөгийн хэмнэлтийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн буюу 2021 оны эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 290.0 сая төгрөг болж 28.8 сая төгрөгөөр өссөн. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 56.9 сая төгрөгийн бараа материал худалдан авч алим хөтөлбөртэй холбоотой услалтын систем, цар тахалтай холбоотой өгсөн иргэдийн өгсөн маск, мал зэрэг 24.2 сая төгрөгийн бараа материалыг хандиваар хүлээн авч сонгууль зохион байгуулахтай холбоотой зардлаас авсан 0.5 сая төгрөгийн бараа материалыг бусад төрөлд бүртгэн авч үйл ажиллагаандаа 52.7 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,619.3 сая төгрөг болж 25.4 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 45.0 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 1.2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг хандиваар хүлээн авч, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийсэн бүтээн байгуулалтын ажил, алим хөтөлбөрийн хүрээнд 24.9 сая төгрөгийн хөрөнгийг бусад төрөлд бүртгэлд авч, Орон нутгийн өмчийн газрын зөвшөөрлөөр 33.4 сая төгрөгийн сумын цагдаагийн байрыг шилжүүлэн авч, 130.0 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлээс хасжээ. Тайлант онд үндсэн хөрөнгөд 237.1 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 1,219.0 сая төгрөг болж 130.2 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн хаасан бичилт хийгээгүй. Тайлант онд хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 461.1 сая төгрөг болсон байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 482.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 140.4 төгрөгөөр бууруулж, 342.5 сая төгрөгөөр баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс өндөр байгаа нь урсгал зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрийн хүрээнд 3 арга хэмжээг орон нутгийн төсвөөс 341.8 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэх 0.7 сая төгрөгийн нийт 342.5 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 341.8 сая төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны хүрээнд 0.8 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж урсгал үйл ажиллагаанд 333.2 сая төгрөгийг зарцуулж 10.3 сая төгрөгийн хэмнэлтийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 333.2 сая төгрөг буюу 97.5 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 5.6 сая сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 0.9 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 0.3 сая төгрөг, хангамж бараа материалын зардлыг 0.5 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж зардлыг 1.9 сая төгрөг бусад зардлын бүлгийг зардлыг 0.1 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 27.9 сая төгрөгийн орлого хүлээн авсан ба ЗГНХ,ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө ангилалд 3.8 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө дансанд 23.2 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого ангилалд 0.9 сая төгрөгийн орлогыг тайлагнасан. Нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрээс хангамж бараа материалын зардалд 11.7 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж зардалд 15.3 сая төгрөгийг зарцуулж 0.9 сая төгрөгийн хэмнэлтийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Засаг даргын тамгын газар нь 2021 онд нийт 91.6 сая төгрөгийн 95 мэдээллийг Шилэн дансны цахим хуудсанд ил тод байршуулахаас 27.0 сая төгрөгийн 11 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, “6.4.4. таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, “6.4.5. цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 0.1 сая төгрөгийн төлбөрийн акт, 16.5 сая төгрөгийн 4 заалт зөрчлийг арилгах албан шаардлага 1 заалт зөвлөмж хүргүүлснийг биелүүлсэн талаар албан бичиг нотлох баримт ирсэн боловч нийгмийн даатгалд цалин илүү тайлагнасан зөрчил давтагдан гарчээ.

Давтагдан гарсан зөрчил нь өмнөх онд зөвлөмж өгсөн зөрчил байх тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан сахилгын шийтгэл ногдуулах заалтыг хэрэглээгүй албан шаардлага хүргүүлээ.

Цаашид аудитын дүн дүгнэлт, илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх зохион байгуулалтын ажлыг оновчтой хэлбэрээр хийж Төрийн аудитын газрын гаргасан дүгнэлт, зөвлөмж, акт, албан шаардлагад ач холбогдол өгч илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх, төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байгааг онцлон дурдъя.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараа жилийн аудитаар нягтлан бодох бүртгэлийн шууд бичилтээр хийсэн гүйлгээ, нягтлан бодох бүртгэлийн шууд бичилтээр хийсэн гүйлгээ, автомашины ашиглалт, нярвын бүх төрлийн тайлангийн иж бүрэн, үнэн зөв байдлыг тус тус анхаарах нь зүйтэй байна.

### **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 69.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 11.9 сая төгрөгийн алдааг залруулж, 7.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 16.4 сая төгрөгийн зөрчилд

албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгч 34.3 сая төгрөгийн асуудлыг Үндэсний аудитын газарт шилжүүлсэн.

#### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар тайлант онд 11.6 сая төгрөгийн худалдан авалтын гүйлгээ төлбөрийн баримтын нэгдсэн системийн баримтын жагсаалтын худалдан авалт төрөлд бүртгэгдээгүй байсныг аудитын хугацаанд нөхөн шивүүлж анхан шатны баримтын шаардлагыг хангуулж, иргэдийн хандиваар хүлээн 0.4 сая төгрөгийн материалыг тодруулга тайланд залруулсан.

#### 4.2 Төлбөрийн акт

Малчин Ч.Лхагваагийн хандиваар өгсөн 7.0 сая төгрөг, завхан гол багийн иргэн Х.Зоригтын өгсөн 0.1 сая төгрөг нийт 7.1 сая төгрөгийг данс бүртгэлд тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-т "Тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана." Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" 13.6-т "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

#### 4.3 Албан шаардлага

Тайлант онд 3.5 сая төгрөгийн худалдан авалтын гүйлгээ төлбөрийн баримтын нэгдсэн системийн баримтын жагсаалтын худалдан авалт төрөлд бүртгэгдээгүй нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Татварын тодорхойлолтоор 1.7 сая төгрөгийн илүү, 0.1 сая төгрөгийн дутуу төлөлтэй боловч санхүүгийн тайланд тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Батлагдсан төсвийг 10 хувиас доошгүй хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.1-т "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн

хуваарилах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Нийгмийн даатгалын хэлтэст 1.2 сая төгрөгийн цалин илүү тайлагнасан нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-т "Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ", 1-т "Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх", 2-т "Шимтгэл оногдуулах, төлөхтэй холбогдсон мэдээ, тайланг тогтоосон хугацаанд гаргаж даатгалын байгууллагад ирүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Байгууллагын данс бүртгэлд байдаг малын гэрээг данс бүртгэлтэй тулгахад 22 толгой 2.4 сая төгрөгийн хонь, 5 толгой 0.3 сая төгрөгийн хээлтүүлэгч /ухна/ дутагдсан, 58 толгой 3.2 сая төгрөгийн ямаа, 2 толгой 0.1 сая төгрөгийн хээлтүүлэгч /хуц/ илүүдсэн гэрээний үнэ болон бүртгэлийн үнэ 0.6 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" 13.6-т "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Малын тоо бүртгэлээр гэрээний хугацаа дууссан 3.2 сая төгрөгийн 4 толгой үхрийг хүлээн авч дараагийн айлд өгөөгүй нь СС-ийн 2000 онд баталсан Эд хариуцагчийн дүрэм, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна.", 67.2.-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна.", 73 дугаар зүйлийн 73.4-т "Үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ. Санаатайгаар идэж ашигласан буюу дутагдуулсан нь илэрвэл хуулийн этгээдийн эрх баригч уг хэргийг 7 хоногийн дотор хуулийн байгууллагад шилжүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

#### 4.4 Зөвлөмж

Аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

##### 1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд 27.0 сая төгрөгийн 11 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.
- 1.2. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.4. таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5. цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн холбогдох заалттай гэсэн заалтыг мөрдөн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4.4 Санал уламжлах

УАЗ-31519 маркийн 34.3 сая төгрөгийн анхны өртөгтэй 15.7 сая төгрөгийн автомашиныг аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 98 дугаартай "Худалдах хөрөнгийн жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулах, худалдах доод үнийг тогтоох тухай" тогтоолоор 0.3 сая төгрөгөөр эзэмшигчид нь худалдах шийдвэр гарсан

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д заасны дагуу гэмт хэргийн шинж чанартай байж болзошгүй гэж үзээд Монгол улсын Ерөнхий аудиторт уламжилж байна.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/сая төгрөгөөр/									
				Үүнээс		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		ҮАГ	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Говь-Алтай аймгийн Жаргалан сумын ЗДТГ	11	69.8	2	11.9	1	7.1	6	16.4	1		1	34.3